



Зориулалт

Цонх болон хаалганы блок суурилуулах, цонхны тавцан, хананы хавтанг бэхлэх, хагарал болон хоосон зайг чигжих, завсарын дулаан болон дуу чимээ тусгаарлах түүнчлэн бусад барилга угсралт, өнгөлгөөний ажилд зориулагдсан.

Өндөр чанарын нэг бүрэлдэхүүнт полиуретан угсралтын хөөс нь бетон, тоосго, гипс, мод, хуванцар гэх мэт полиэтилен, полипропилен, фторопластикаас бусад барилгын ихэнх материалд маш сайн наалдаж өгдөг. Нэгэн жигд, тогтвортой гаралтыг хангаж, бэлэн болсон хөөс нь гайхалтай нягтралтай бүтцийг бий болгодог.

Бүрэн хатсан DOWELL хөөс нь давхаргын гадаргуугийн гидрофобик чанар нэмэгдэж, битүүлсэн нүхний өндөр агууламжийн ачаар угсралтын завсараар чийгтэй агаар нэвтрэхийг багасгаж, улмаар цаг уурын янз бүрийн нөхцөлд завсарын өндөр дулаан тусгаарлалтыг хадгалж барилга байгууламжийн халаалтын зардлыг бууруулдаг.

Хэрэглэх заавар

- Ажлыг -10°C-аас +35°C хүртэл температурт, агаарын харьцангуй чийгшил 50%-аас доошгүй үед хийхийг зөвлөж байна.
- Хөөсийг их хэмжээгээр гаргах болон физик-механикийн үзүүлэлтүүдийг оновчтой байлгахын тулд ашиглахын өмнө баллоныг +18°C-ээс +20°C-ын хэмд 10 цагаас багагүй хугацаанд байлгах хэрэгтэй.
- Цэвэрхэн ажиллахын тулд зэргэлдээх гадаргууг будагын скочоор хучихыг зөвлөж байна.
- Урьдчилж тоос, шаавар, тос, мөс, хяруу зэрэг бохирдлыг цэвэрлэсэн гадаргуу дээр хөөсийг хэрэглэнэ.

Хөөсийг хэрэглэхээс өмнө ажиллах гадаргууг чийгшүүлнэ. Орчны температур 0°C-ээс дээш тохиолдолд ус, 0°C-ээс доош тохиолдолд KUDO "Угсралтын хөөс идэвхжүүлэгч" хэрэглэнэ.

Баллоныг доош харуулсан байдалтай ажиллана.

- Баллоныг 30 секундын турш 15-аас доошгүй удаа сайтар сэгсэрнэ.
- Хамгаалалтын тагийг авна.
- Полиэтилен хоолойтой адаптерийг баллоны хавхлагат бэхлэнэ.
- Угсралтын хөөсийг доороос дээш чиглэлтэйгээр хагархайн 1/2 хэсгийг дүүргэж түрхэнэ.
- Хөөсний гаралтыг адаптер дээр дарж тохируулж болно.
- Ашиглалтын явцад баллоныг тогтмол сэгсэрнэ.
- Хэрэглэсний дараа хөөсийг шуригчийн тусламжтай чийгшүүлнэ.
- Хатаагүй хөөсийг «Очистителем монтажной пены» "Угсралтын хөөс цэвэрлэгч" ашиглан арилгана.
- Бүрэн хатуурсны дараа илүүдэл хөөсийг хутгаар зүсэж авна.
- Хатуурсан хөөсөнд «Удалитель застывшей монтажной пены» "Хатсан угсралтын хөөс арилгагч" хэрэглэнэ.
- Бүрэн полимержилтын дараа (24-48 цаг) хатуурсан хөөсийг зүсэж, гилсдэж, будаж болно.
- Хэт ягаан туяа болон хур тунадасын нөлөөллөөс хамгаална.

Өнгө	цагаан
Хөөсний гаралт	40 литр хүртэл*
Зүслэлийн бүтэц	нэг төрлийн нарийн сүвэрхэг
Хоёрдогч тэлэлт	2-3 удаа
Арьс үүсэх хугацаа	15 минут хүртэл*
Үндсэн боловсруулалтын хугацаа	45 минут хүртэл*
Бүрэн полимержих хугацаа	24-48 цаг
Нягтрал	15-30 кг / м3
Орчны температур	-10°C ... +35°C
Баллоны температур	+17°C ... +30°C (хамгийн оновчтой +18°C ... +20°C)
Хатуурсан хөөсний дулаан тэсвэрлэх чадвар	-40°C ... +90°C
Хадгалах температур	+5°C ... +25°C

* +23°C температурт, агаарын харьцангуй чийгшил 50. %

Хадгалах хугацаа: Хадгалах горимыг хангасан тохиолдолд 12 сар

Хэмжээ: 1000 мл

DPH10U40

EAN: 4606445044447

ITF: 14606445044444